

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/154/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Албан шаардлага	16
5.2 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХК	Хувьцаат компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.24

№

2/101

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Оны эцэст эд хөрөнгийн тооллогыг явуулахдаа тооллогын комисс бараа материалыг тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй;
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулаагүй зөрчил өмнөх онд илэрсэнд зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу мэдээлсэн зөрчил дахин давтагдсан зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай

D/2023-A4 Alban toot.doc

005020403

хуулийн 70-73 дугаар зүйл, УСНББОУС 17, УСНББОУС 19, болон Оршин байх, Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2022 онд 70426 (Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх) хөтөлбөрийн 2 арга хэмжээний зардалд 197,704.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсаны 196,704.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, туслах үйл ажиллагааны орлогоор буюу цахим тендерийн орлогоор 10,000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөсөн байна. Цахим тендерийн хураамжийн орлогоор 8,645.0 мянган төгрөг орж, орлогын төлөвлөгөө 1,355.0 мянган төгрөгөөр тасарсан ба тасарсан орлогыг дуудлага худалдааны орлогоос зарцуулж, төсөв хэтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2020 оны 9, 2021 оны 278 дугаар тогтоол, ТБӨЗГ-ын 2022 оны 64 дүгээр тогтоол, Баянхонгор аймгийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын 3.1.3 дахь заалтын дагуу 2022 онд төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 17,600.0 мянган төгрөгийг олгосон байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар орлогын гүйцэтгэлийг санхүүгийн тайлан, Э-тайланд зөв дансаар бүртгэж, үнэн зөв тайлагнаагүй, эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, Шилэн дансны тухай хуулийг мөрдөөгүйгээс өмнөх оны зөрчил давтагдан гарсан, худалдан авсан үндсэн хөрөнгийн анхны өртгийг зөрүүтэй бүртгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Баянхонгор аймгийн Засаг дарга 99.7 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,292,929.38</u>	<u>43,766,684.00</u>
33	АВЛАГА	5,629,335.38	00.00
335	Бусад авлага	5,629,335.38	00.00
3351	Байгууллагаас авах авлага	5,629,335.38	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,663,594.00	43,766,684.00
354	Хангамжийн материал	42,663,594.00	43,766,684.00
35410	Бичиг хэргийн материал	553,809.00	348,899.00
35420	Аж ахуйн материал	12,109,785.00	13,417,785.00
35470	Бусад хангамжийн материал	30,000,000.00	30,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,063,388,469.95</u>	<u>10,238,191,588.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,063,388,469.95	10,238,191,588.12
392	Биет хөрөнгө	11,063,388,469.95	10,231,801,288.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,466,997,466.21	13,466,997,466.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,506,805,463.65	-3,402,068,872.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	772,812,390.06	852,012,390.06
39204	Хуримтлагдсан элэгдэл	-745,229,056.76	-758,947,806.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,287,300.00	54,517,335.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,681,623.94	-31,769,524.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,271,120.00	20,271,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,251,505.38	-13,377,890.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,321,341.50	61,321,341.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,651,798.09	-17,472,570.65
39217	Ном	318,300.00	318,300.00
393	Биет бус хөрөнгө	00.00	6,390,300.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	6,390,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,111,681,399.33</u>	<u>10,281,958,272.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,818,223,385.83</u>	<u>4,335,000,000.00</u>
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,818,223,385.83	4,335,000,000.00
421	Урт хугацаат үнэт цаас	4,818,223,385.83	4,335,000,000.00
4211	Төгрөг	4,818,223,385.83	4,335,000,000.00
42111	Бонд	4,818,223,385.83	4,335,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,293,458,013.50</u>	<u>5,946,958,272.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,293,458,013.50	5,946,958,272.12
512	Хуримтлагдсан үр дүн	1,193,533,923.02	847,034,181.64
51210	Өмнөх үеийн үр дүн	-286,829,500.21	1,676,497,408.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-829,463,227.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,099,924,090.48	5,099,924,090.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,111,681,399.33</u>	<u>10,281,958,272.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,604,006,935.00	397,813,235.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,418,199,565.00	192,509,135.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,418,199,565.00	192,509,135.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,500,550.00	102,323,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,500,550.00	102,323,800.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	2,352,204,315.00	88,957,335.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал	494,700.00	1,228,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	185,807,370.00	205,304,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,571,870.00	17,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	17,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,571,870.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	180,235,500.00	187,704,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	180,235,500.00	187,704,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,098,858,417.39	1,227,276,462.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,098,858,417.39	1,227,276,462.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,037,425,011.41	1,133,354,216.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,244,798.00	147,647,000.00
210101	Үндсэн цалин	94,341,436.00	110,409,175.00
210102	Нэмэгдэл	33,483,362.00	22,646,139.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,420,000.00	13,930,000.00
210104	Урамшуулал	00.00	661,686.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,292,682.70	18,416,244.38
210201	Тэтгэврийн даатгал	13,160,259.10	12,510,348.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,267,290.35	1,476,499.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,129,957.69	1,181,199.08
210204	Ажилгүйдлийн даатгал	267,877.60	295,299.11
210205	Эрүүл мэндийн даатгал	2,467,297.96	2,952,899.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	180,000.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,298,229.32	12,642,161.43
210401	Бичиг хэрэг	3,285,330.00	4,642,160.00
210402	Тээвэр, шатахуун	4,662,900.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199,999.32	1,800,001.43
210404	Ном, хэвлэл	150,000.00	200,000.00
2105	Нормативт зардал	2,000,000.00	1,500,000.00
210502	Хоол, хүнс	2,000,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,850,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,850,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,838,500.00	5,201,300.00
210702	Дотоод албан томилолт	2,838,500.00	5,201,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,947,004.00	25,587,934.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,619,940.00	25,088,870.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	199,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,064.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	855,803,797.39	920,329,576.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	312,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	855,803,797.39	920,017,216.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,433,405.98	93,922,245.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,150,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,150,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,500,550.00	92,282,900.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,500,550.00	92,282,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	782,855.98	139,345.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	782,855.98	139,345.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,505,148,517.61	-829,463,227.21
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,785,094.38	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-24,785,094.38	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,480,363,423.23	-829,463,227.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	251,307,920.00	313,199,770.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,500,550.00	102,323,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	65,500,550.00	102,323,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,500,550.00	102,323,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,500,550.00	92,282,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	10,040,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	185,807,370.00	210,875,970.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,571,870.00	23,171,870.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	17,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,571,870.00	5,571,870.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	180,235,500.00	187,704,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	180,235,500.00	187,704,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	251,307,920.00	307,336,770.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,307,920.00	307,336,770.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,302,644.02	213,414,524.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,244,798.00	147,647,000.00
210101	Үндсэн цалин	94,341,436.00	110,409,175.00
210102	Нэмэгдэл	33,483,362.00	22,646,139.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,420,000.00	13,930,000.00
210104	Урамшуулал	00.00	661,686.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,292,682.70	18,358,779.00
210201	Тэтгэврийн даатгал	12,791,028.85	12,452,882.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,425,047.98	1,476,499.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,129,957.69	1,181,199.08
210204	Ажилгүйдлийн даатгал	267,877.60	295,299.11
210205	Эрүүл мэндийн даатгал	2,678,770.58	2,952,899.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	180,000.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,892,099.32	12,557,151.43
210401	Бичиг хэрэг	4,200,000.00	4,557,150.00
210402	Тээвэр, шатахуун	4,342,100.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199,999.32	1,800,001.43
210404	Ном, хэвлэл	150,000.00	200,000.00
2105	Нормативт зардал	2,000,000.00	1,500,000.00
210502	Хоол, хүнс	2,000,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	1,850,000.00
210602	Тавилга	2,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,850,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,838,500.00	5,201,300.00
210702	Дотоод албан томилолт	2,838,500.00	5,201,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,034,564.00	25,807,934.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,707,500.00	25,308,870.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	199,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,064.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	312,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	312,360.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,005,275.98	93,922,245.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,150,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,150,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,500,550.00	92,282,900.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,500,550.00	92,282,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	782,855.98	139,345.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	782,855.98	139,345.57
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,571,870.00	00.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	5,571,870.00	00.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,863,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	5,863,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	5,863,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,863,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,863,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,863,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,863,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-5,863,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,099,924,090.48	-286,829,500.21	4,813,094,590.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,099,924,090.48	-286,829,500.21	4,813,094,590.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	1,480,363,423.23	1,480,363,423.23
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,099,924,090.48	1,193,533,923.02	6,293,458,013.50
D01	2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,099,924,090.48	1,193,533,923.02	6,293,458,013.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	482,963,485.83	482,963,485.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,099,924,090.48	1,676,497,408.85	6,776,421,499.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-829,463,227.21	-829,463,227.21
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,099,924,090.48	847,034,181.64	5,946,958,272.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	197,704,100.00	197,605,654.43	98,445.57	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,704,100.00	197,605,654.43	98,445.57	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,204,100.00	196,105,654.43	98,445.57	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,647,100.00	147,647,000.00	100.00	100.0
210101	Үндсэн цалин	105,529,100.00	110,409,175.00	(4,880,075.00)	104.6

210102	Нэмэгдэл	24,177,900.00	22,646,139.00	1,531,761.00	93.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,940,000.00	13,930,000.00	4,010,000.00	77.6
210104	Урамшуулал	00.00	661,686.00	(661,686.00)	#DIV/0!
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,455,900.00	18,358,779.00	97,121.00	99.5
210201	Тэтгэврийн даатгал	12,550,000.00	12,452,882.72	97,117.28	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,476,500.00	1,476,499.01	0.99	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,181,200.00	1,181,199.08	0.92	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	295,300.00	295,299.11	0.89	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,952,900.00	2,952,899.08	0.92	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,557,500.00	12,557,151.43	348.57	100.0
210401	Бичиг хэрэг	4,557,500.00	4,557,150.00	350.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,800,001.43	(1.43)	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,500,000.00	6,499,064.00	936.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	199,064.00	936.00	99.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312400.00	312360.00	40.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	312,400.00	312,360.00	40.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	197,704,100.00	197,605,654.43	98,445.57	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,704,100.00	187,564,754.43	139,345.57	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	187,704,100.00	187,564,754.43	139,345.57	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	10,040,900.00	(40,900.00)	100.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,040,900.00	(40,900.00)	100.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00	0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13.00	13.00	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	04.00	04.00	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,171,870.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,171,870.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,171,870.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,902,370.00
210401	Бичиг хэрэг	472,370.00
210402	Тээвэр, шатахуун	4,430,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,434,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,863,000.00
210604	Урсгал засвар	5,571,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,835,500.00
210702	Дотоод албан томилолт	8,835,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,171,870.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,571,870.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн ОНӨГ "Орон нутгийн төсөвт байгууллагууд болон Төрийн өмчийн оролцоотой орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өмч, хөрөнгийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд зохицуулах мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог олон улсын стандартад хүргэж, бүх шатны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт, үр ашиг, ил тод байдал, харилцан тайлагнах болон хариуцлагын зарчмуудыг баталгаажуулж, авлига гарах нөхцөлийг бууруулах, дотоодын үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийг дэмжих шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг хурдасгахад дэмжлэг үзүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь 13 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Ц.Идэрмөнх, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Дуламсүрэн нар зурж, нярваар архив, бичиг хэргийн ажилтан М.Пүрэвдулам нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 829,723.1 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	5,629.34	0.00	(5,629.34)
Бараа материал	42,663.59	43,766.68	1,103.09
Үндсэн хөрөнгө	14,367,457.9	14,462,278.3	94,820.4
Хуримтлагдсан элэгдэл	(3,304,069.4)	(4,224,086.7)	(920,017.3)
Нийт хөрөнгө	11,111,681.40	10,281,958.27	(829,723.13)
Өр төлбөр	4,818,223.39	4,335,000.00	(483,223.39)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,293,458.01	5,946,958.27	(346,499.74)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,111,681.40	10,281,958.27	(829,723.13)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Үндсэн үйл ажиллагааны давсан орлогын 5,629.3 мянган төгрөгийг 2021 оны эцэст төсөвт төвлөрүүлж, авлагаар бүртгэснийг 2022 онд харилцах дансанд орсноор өмнөх оны авлага хаагдаж, засварын зардалд зарцуулсан байна.

Төсвийн хөрөнгөөр 2,000.0 мянга, нэмэлт санхүүжилтийн данснаас 4,888.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/26 дугаар тогтоолоор Зоонозын өвчин судлалын төвд ашиглаж байсан 39,500.0 мянга, Шүүхийн шинжилгээний албанд ашиглаж байсан 39,700.0 мянган төгрөгийн 2 суудлын автомашиныг шилжүүлэн бүртгэсэн байна. ТӨБЗГ-ын даргын Б/106 дугаар тушаалаар хуваарилсан 2,342.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер санхүүгийн тайланд бүрэн бүртгэж, аж ахуйн хашааны 2100м² талбай бүхий 6,390.3 мянган төгрөгийн газрыг биет бус хөрөнгөд бүртгэжээ.

Тус байгууллагын санхүүгийн тайланд “Чандмань Баянхонгор” ХК-ийн урт хугацаат зээл бүртгэлтэй, Сангийн яамтай Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч тооцоо нийлснээр тус урт хугацаат зээлээс 483,223.4 мянган төгрөгийн зээлийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 829,463.2 мянган төгрөгөөр буурч, 847,034.2 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн барагдуулсан урт хугацаат өр төлбөрийн 483,223.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 847,034.2 мянган төгрөгөөр буурч, 5,946,958.3 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 260,557.8 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 62,054.9 мянган төгрөгөөр хасаж, төсвийг 198,502.9 мянган төгрөгөөр баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу цалин хөлс, нэмэгдэл урамшууллаас бусад томилолт, бичиг хэрэг, бусад зардлуудыг 60 хувиар хасаж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эхэнд баталсан төсвийг 2022.11.10-ны өдөр томилолтын зардлыг 798.8 мянган төгрөгөөр бууруулж, 197,704.1 мянган төгрөгөөр баталж, 196,704.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, 10,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор оруулахаар төлөвлөжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70426 (Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан 196,704.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 196,564.7 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 139.3 мянган төгрөгийг оны эцэст Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

Цахим тендерийн хураамжийн орлогоор 10,000.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 8,645.0 мянган төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөө 1,355.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь өмнөх оноос цахим тендерт оролцогчдын тоо бага байсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Арга хэмжээ 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	196,204.10	196,105.65	98.45	100%
2	Арга хэмжээ 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,500.00	1,500.00	-	100%
Дүн		197,704.10	197,605.65	98.45	100%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/148, А/379, А/614 дүгээр захирамжаар төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын зардалд олгосон 17,600.0 мянга, өмнөх оны авлагын 5,571.9 мянга, нийт 23,171.9 мянган төгрөгийн орлого орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материалын тайланг шаардах хуудсыг үндэслэн тайлагнах, тооллогын үр дүнг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж, тооцоо бодсон актыг хуульд заасан хугацаанд нь гаргах, санхүүгийн тайлан болон Э-тайланд орлогыг зөв дансаар тайлагнаж байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.12.08-ны өдрийн А/311 дүгээр албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 197,704.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,966.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,075.9 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн ОНӨГ нь 2022 онд тээвэр шатахууны зардалд 6,000.0 мянган төгрөгийг зарцуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэснийг зөрчсөн тул менежментийн захидлаар хуулийг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 204,701.1 мянган төгрөгийн 13 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 2,499.2 мянган төгрөгийн 3 шийдвэрийг мэдээлсэн байна.

Харин аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 7,421.0 мянган төгрөгийн 4 гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 89,571.9 мянган төгрөгийн орлогын 6, 107,678.9 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл дутуу байршуулсан зөрчил өмнөх онд илэрч зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаагүй тул албан шаардлагыг өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, 1,800.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, менежментийн захидлаар 154,925.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	1,800.0	1	1,800.0	100%
Зөвлөмж	1	154,925.6	1	154,925.6	50%
Нийт дүн	2	156,725.6	2	156,725.6	75%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022.04.13-ны өдрийн А/94 дүгээр албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2022.04.13-ны өдрийн А/94 дүгээр албан бичгээр ирүүлсэн, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээ тайланг цаг хугацаанд нь мэдээлж байна гэж ирүүлсэн боловч Шилэн дансны тухай хуулийн дагуу таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий, орлого, зарлагыг мэдээлээгүй орхигдуулсан зөрчил 2022 онд давтан гаргасан байна. Иймд зөвлөмжийг хэрэгжилтийг 50 хувиар тооцож, шилэн дансны цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,581.7 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс 3,025.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 45,556.7 мянган төгрөгийн дүн бүхий 5 зөвлөмжийг менежментийн захидлаар өглөө.

5.1 Албан шаардлага

1. "Би Си Ти" ХХК-аас 1,512.5 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг суурин компьютерыг нийт 3,025.0 мянган төгрөгөөр худалдан авсныг санхүүгийн тайланд анхны өртгөөс зөрүүтэй үнээр буюу 2,000.0 мянга болон 1,025.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", байгууллагын мөрдөж буй НБББББ-ийн 4.4.4 дэх заалтыг зөрчиж байгаа тул суурин компьютерын анхны өртгийг залруулж бүртгэх албан шаардлагыг өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 7,421.0 мянган төгрөгийн 4 гэрээг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 89,571.8 мянган төгрөгийн орлогын 6, 107,678.9 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээ болон 2022.09.23-ны өдрийн А/18 дугаар тушаалыг мэдээлээгүй орхигдуулсан, өмнөх оны аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил 2022 онд давтагдан гарсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн тул орхигдуулсан мэдээллийг нөхөн байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цахим тендерийн орлогын төлөвлөгөөг тайлант онд 10,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8,645.0 мянган төгрөгөөр орж, орлогын төлөвлөгөө 1,355.0 мянган төгрөгөөр тасарсан байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогын гүйцэтгэлийг 10,0490.0 мянган төгрөгөөр тайлагнаж, дутагдсан 1,395.9 мянган төгрөгийг дуудлага худалдааны орлогоос зарцуулж, төсөв хэтрүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, орлогын гүйцэтгэлийг санхүүгийн тайланд зөв тайлагнаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах

2. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын даргын 2022.12.12-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар томилогдсон комисс эд хөрөнгийн тооллогыг явуулахдаа бараа материалыг тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Няrvын бэлтгэсэн шатахууны тайлангийн орлого, зарлага санхүүгийн тайлангийн дүнгээс 300.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлант оны 4, 5, 11 сард нийт 135.0 мянган төгрөгийн 8 боодол цаасыг олгосон анхан шатны баримтын бүрдэл дутуу.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтад үндэслэн бараа материалын тайланг үнэн зөв бүртгэх, анхан шатны баримтыг санхүүгийн тайланд бүрэн хавсаргах

4. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн журналд санхүүжилтийг дансны хуулганаас зөрүүтэй дүнгээр бүртгэсэн, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн санхүүжилт, өөрийн орлогын дүнг зөв тайлагнаагүй, Э-тайлангийн тодруулгад төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг зөв тайлагнаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгаас олгосон санхүүжилтийг төрийн сангийн дансны хуулганд тулгуурлан санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэж, орлого, худалдан авсан үндсэн хөрөнгийг Э-тайланд зөв дүнгээр тайлагнах

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд тээвэр шатахууны зардалд 6,000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох албан хаагчдад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим тендерийн орлогын төлөвлөгөөг тайлант онд 10,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8,645.0 мянган төгрөгөөр орж, орлогын төлөвлөгөө 1,355.0 мянган төгрөгөөр тасарсан байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогын гүйцэтгэлийг 10,0490.0 мянган төгрөгөөр тайлагнаж, дутагдсан 1,395.9 мянган төгрөгийг дуудлага худалдааны орлогоос зарцуулж, төсөв хэтрүүлсэн байна.	1	1,256.6					1	1,256.6				
Оны эцэст эд хөрөнгийн тооллогыг явуулахдаа тооллогын комисс бараа материалыг тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй байна.	1	43,766.7					1	43,766.7				
"Би Си Ти" ХХК-аас 1,512.5 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг суурин компьютерыг нийт 3,025.0 мянган төгрөгөөр худалдан авч, үндсэн хөрөнгөд бүртгэхдээ 2,000.0 болон 1,025.0 мянган төгрөгөөр бүртгэж, анхны өртгөөс зөрүүтэй үнээр хөрөнгийг бүртгэсэн байна.	1	3,025.0			1	3,025.0						
Нярвын бэлтгэсэн шатахууны тайлангийн орлого, зарлага санхүүгийн тайлангийн дүнгээс 300.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлант оны 4, 5, 11 сард нийт 135.0 мянган төгрөгийн 8 ширхэг бичгийн цаасыг олгосон анхан шатны баримтын бүрдэл дутуу.	1	435.0					1	435.0				
Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн	1	-					1	0.0				

санхүүжилт, өөрийн орлогын дүнг зөв тайлагнаагүй, Э-тайлангийн тодруулгад төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг зөв тайлагнаагүй байна.												
Дүн	5	48,483.3	0	-	1	3,025.0	4	45,458.3	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 7,421.0 мянган төгрөгийн 4 гэрээг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 89,571.8 мянган төгрөгийн 6 орлогын, 107,678.9 мянган төгрөгийн 6 зарлагын гүйлгээ болон 2022.09.23-ны өдрийн А/18 дугаар тушаалыг мэдээлээгүй орхигдуулсан байна.	1	0			1	0		
Дүн	1	0	0	0	1	0	0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Тайлант онд тээвэр шатахууны зардалд 6,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	6,000.0					1	6,000.0
Дүн	1	6,000.0	0	-	0	-	1	6,000.0
Нийт дүн	2	6,000.0	0	-	1	-	1	6,000.0

---oOo---